



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 03 сарын 22 өдөр

Дугаар А/77

Цагаан-Уул сум

┌ Мал амьтаны сэг зэм устгал, ┐  
халдваргүйтгэлийн ажил зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Монгол Улсын Засгийн газрын 62 дугаар тогтоол, Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2024 оны А/40 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын хэмжээнд зүй бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, булшлах, орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн ажлыг 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. Зүй бусаар хорогдсон малын сэг зэмийг цуглуулах, устгах, булшлах, цэвэрлэх ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар, шатах тослох материал болон бусад зардлыг 2 дугаар хавсралтаар, Хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслийг 3 дугаар хавсралтаар, ажлын төлөвлөгөөг 4 дүгээр хавсралтаар, дайчилгаанд хамрагдах албан хаагчдын нэрсийг 5 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардлагатай хүн хүч, машин техник, шатахуун, хөдөлмөр хамгаалалын хувцас бусад зардлыг шийдвэрлэж ажиллахыг Сумын шуурхай штабын дарга, Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр), мэргэжил арга зүйн удирдлагаар ханган, ажлын явц, чанар гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга Улсын байцаагч (Т.Чандмаа) нарт тус тус даалгасугай.

4. Сэг зэм устгал, ариутгал халдваргүйтгэлийн ажлыг баг тус бүрт ажлын хэсэг байгуулж, малчид иргэдтэй хамтран ажиллахыг багийн дарга нарт үүрэг болгосугай.

5. Хэрэгжилтийн тайланг 2024 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн дотор сумын Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулахыг Байгаль орчин тогтвортой хөгжлийн бодлогын тасгийн дарга (У.Аварзэд)-д даалгасугай.

6. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Түмэнбаяр)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ

